



**ЗАВХАН АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2022 оны 05 сарын 24 өдөр

Дугаар А/293

Улиастай

Захирамжийн хавсралтад нэмэлт,  
өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, 60 дугаар зүйлийн 60.1.1 дэх заалт, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 21 дүгээр зүйл, Засгийн газрын 2021 оны 374 дүгээр тогтоолыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. "Журам шинэчлэн батлах тухай" аймгийн Засаг даргын 2021 оны А/221 дүгээр захирамжийн хавсралтад дор дурдсан агуулгатай дэд заалт, заалт нэмсүгэй.

1/3.2.3.2 дахь дэд заалт:

"3.2.3.2. Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт туссан Засгийн газрын тэргүүлэх ач холбогдолтой төсөл, арга хэмжээг үнэлэх шалгуур үзүүлэлтийн биелэлт;"

2/9.8 дахь заалт:

"9.8. Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт туссан Засгийн газрын тэргүүлэх ач холбогдолтой төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийн үнэлгээг журмын 14 дүгээр хавсралтаар гаргаж, 1 дүгээр хавсралтад заасан хугацаанд аймгийн Засаг даргын Тамгын газарт ирүүлнэ."

2. Мөн журмын 3.2.3.8, 9.7, 9.8, 11.1, дэх заалт, дэд заалтыг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай.

1/3.2.3.8 дахь дэд заалт:

"3.2.3.8. Монгол Улсын Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх гэрээний хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт;"

2/9.7 дахь заалт:

"9.7. Монгол Улсын Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх гэрээний үүргийн хэрэгжилтийг журмын 13б хавсралтаар гаргаж, 1 дүгээр хавсралтад заасан хугацаанд аймгийн Засаг даргын Тамгын газарт ирүүлнэ."

3/9.8 дахь заалт

“Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт туссан Засгийн газрын тэргүүлэх ач холбогдолтой төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийн үнэлгээг журмын 14 дүгээр хавсралтаар гаргаж, 1 дүгээр хавсралтад заасан хугацаанд аймгийн Засаг даргын Тамгын газарт ирүүлнэ.”

4. Мөн журмын 3.2.1 дэх дэд заалтад "4.1.4-4.1.14, 9.6.5" гэж, 3.2.3.2-3.2.3.13 дахь дэд заалтын дугаарлалтыг "3.2.3.3-3.2.3.14" гэж, 9.1-9.9 дэх заалтыг 9.1-9.10 гэж, 6.2.3.2 дахь дэд заалтын "99" гэснийг "100" гэж, 6.2.3.3 дахь дэд заалтын "31-69" гэснийг "30-70" гэж, 6.3.2 дахь дэд заалтын "89" гэснийг "90" гэж, 6.3.3 дахь дэд заалтын "49" гэснийг "50" гэж, 6.3.4 дэх дэд заалтын "9" гэснийг "10" гэж, 6.7 дахь заалтад "Монгол Улсын Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх гэрээний хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт" гэж, 9.5 дахь заалтад "Мэдээллийн ил тод, нээлттэй байдлын үнэлгээний тайлан" гэж тус тус өөрчилсүгэй.

5. Мөн журмын 3 дугаар хавсралтыг 3а, 3б, 3в хавсралт болгон хавсралт ёсоор өөрчлөн баталсугай.

6. "Монгол Улсын Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх гэрээний хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, хэрэгжилтийг тайлагнах загвар"-ыг мөн журмын 13а, 13б хавсралт болгон баталсугай.

7. Журмын 6, 7, 8 дугаар хавсралтад "Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт туссан Засгийн газрын тэргүүлэх ач холбогдолтой төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийн үнэлгээ" гэсэн шалгуур үзүүлэлтийг нэмсүгэй.

8. "Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт туссан Засгийн газрын тэргүүлэх ач холбогдолтой төсөл, арга хэмжээг үнэлэх шалгуур үзүүлэлт"-ийг мөн журмын 14 дүгээр хавсралт болгон баталсугай.

9. Энэхүү журамд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг 2022 оны 6 дугаар сарын 1-нээс эхлэн үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг хэлтэс, агентлаг, сумын Засаг дарга нарт, 2021 оны А/221 дүгээр захирамжид нэмэлт өөрчлөлт оруулсан тэмдэглэл хийхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль эрх зүйн хэлтэс (Н.Цогтсайхан)-т үүрэг болгосугай.

10. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс (Н.Бямбадорж)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Д.ТҮВШИНЖАРГАЛ

**БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТ, ЗАХИРГААНЫ  
БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ,  
ҮНЭЛГЭЭ ХИЙХ НИЙТЛЭГ ЖУРАМ**

**Нэг. Нийтлэг үндэслэл**

1.1. Энэ журмаар хөгжлийн бодлогын баримт бичиг (цаашид “бодлогын баримт бичиг” гэх), Монгол Улсын хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн шийдвэр, Засгийн газар болон аймгийн Засаг даргын шийдвэр (цаашид “хууль тогтоомж, тогтоол, шийдвэр” гэх)-ийн хэрэгжилтийг зохион байгуулах, явц, үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, төрийн захиргааны болон нутгийн захиргааны байгууллага (цаашид “захиргааны байгууллага” гэх)-ын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх, тайлагнахтай холбогдсон харилцааг зохицуулна.

1.2. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго нь Монгол улсын Засгийн газрын 206 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх хүрээнд төрийн бодлого, төлөвлөлт, үйл ажиллагааны гүйцэтгэл, үр дүн, үр нөлөөг нэмэгдүүлэх, хэрэгжилт, хариуцлагыг сайжруулахад оршино.

1.3. Захиргааны байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээний тогтолцоо, хүний нөөцийн чадавхыг сайжруулах асуудлыг нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангах, мэргэжил, арга зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх ажлыг аймгийн Засаг даргын Тамгын газар зохион байгуулна.

1.4 Байгууллагын дотоод хяналт-шинжилгээ, үнэлгээг тухайн байгууллагын дарга, холбогдох ажилтан, нэгж хариуцан зохион байгуулж, мэргэжил арга зүйгээр хангана.

**Хоёр. Нэр томъёоны тодорхойлолт**

2.1. Энэ журамд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

2.1.1. "хяналт-шинжилгээ" гэж байгууллагын үйл ажиллагаа болон бодлогын зорилго, зорилт, тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийн явцыг урьдчилан тодорхойлсон шалгуур үзүүлэлтийн дагуу хянах, мэдээлэх тасралтгүй үйл ажиллагааг;

2.1.2. "үнэлгээ" гэж байгууллагын үйл ажиллагаа, бодлогын баримт бичгийн зорилго, зорилтын хэрэгжилтийг төлөвлөсөн зорилтот түвшинд хүрсэн эсэхэд дүн шинжилгээ хийж өгсөн үнэлэлтийг;

2.1.3. "үр дүнд суурилсан явцын үнэлгээ" гэж хяналт-шинжилгээний мэдээлэлд үндэслэн зорилтот түвшинд хүрч байгаа эсэхэд үнэлгээ хийх, хүрээгүй бол шалтгаан нөхцөлийг тодорхойлж, үр дүнг сайжруулах дүгнэлт, зөвлөмж гаргах үйл ажиллагааг;

2.1.4. "үр дүнд суурилсан эцсийн үнэлгээ" гэж бодлогын баримт бичиг хэрэгжиж дууссаны дараа хэрэгжилтийг үнэлж, үр дүн, үр ашиг, үр нөлөөг тодорхойлон цаашид тухайн чиглэлээр бодлого боловсруулан хэрэгжүүлэх, эсхүл зогсоох талаар дүгнэлт, зөвлөмж гаргах үйл ажиллагааг;

2.1.5. "хөндлөнгийн үнэлгээ" гэж бодлогын баримт бичгийн хэрэгжилт, үр дүн, байгууллагын үйл ажиллагаанд хөндлөнгийн мэргэжлийн байгууллага, судлаач, үнэлгээчдийн хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээг;

2.1.6. "шалгуур үзүүлэлт" гэж бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн үе шат бүрт бий болох өөрчлөлтийг хэмжихээр урьдчилан тодорхойлсон чанарын болон тоон үзүүлэлтийг;

2.1.7. "суурь түвшин" гэж үйл ажиллагаа болон бодлогын баримт бичиг, хэрэгжиж эхлэх үеийн шалгуур үзүүлэлтийн чанарын болон тоон утгыг;

2.1.8. "зорилтот түвшин" гэж тухайн бодлогын баримт бичгийг хэрэгжүүлэх явцад болон хэрэгжиж дуусахад хүрэхээр хүлээгдэж байгаа өөрчлөлтийг хэмжихээр урьдчилан тодорхойлсон шалгуур үзүүлэлтийн чанарын болон тоон утгыг.

### **Гурав. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зарчим, хамрах хүрээ**

3.1. Хяналт-шинжилгээ, үнэлгээг хийхэд дараах зарчмыг баримтална:

3.1.1. шударга, хараат бус байх;

3.1.2. хяналт-шинжилгээ, үнэлгээний үйл ажиллагаа нээлттэй, тэдгээрээс гаргасан тайлан, дүгнэлт нь ил тод байх;

3.1.3. хяналт-шинжилгээ, үнэлгээ нь шалгуур үзүүлэлт, тоо баримт, судалгаа, шинжилгээнд үндэслэсэн байх;

3.1.4. хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан дүгнэлт нь тухайн бодлого, үйл ажиллагааны үр дүн, үр нөлөөг тодорхойлсон, нотлогдохуйц байх;

3.1.5. хяналт-шинжилгээг тасралтгүй, үнэлгээг тогтмол, тодорхой үе шаттай хийдэг байх;

3.1.6. хяналт-шинжилгээ үнэлгээ хийхдээ хэрэглэгч, оролцогч болон олон нийтийн оролцоог хангасан байх;

3.1.7. хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланд тусгагдсан мэдээллийн үнэн зөв байдлыг холбогдох захиргааны байгууллага, албан тушаалтан хариуцдаг байх.

3.2. Хяналт-шинжилгээ, үнэлгээний хамрах хүрээнд дараах бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол, шийдвэр, захиргааны байгууллагын үйл ажиллагаа багтана:

**3.2.1. Бодлогын баримт бичигт Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 4.1.4-4.1.14, 9.6.5 заасан баримт бичгүүд хамаарна. Үүнд:**

3.2.1.1. Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг /алсын хараа 2050/

3.2.1.2. Хүний хөгжлийн зорилтот хөтөлбөр

3.2.1.3. Нийгмийн хөгжлийн зорилтот хөтөлбөр

3.2.1.4. Эдийн засгийн болон дэд бүтцийн хөгжлийн зорилтот хөтөлбөр

3.2.1.5. Байгаль орчны зорилтот хөтөлбөр

3.2.1.6. Засаглалын зорилтот хөтөлбөр

3.2.1.7. Бүсийн хөгжлийн зорилтот хөтөлбөр

3.2.1.8. Үндэсний өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх зорилтот хөтөлбөр

3.2.1.9. Монгол улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл

3.2.1.10. Аймаг, хотыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл

3.2.1.11. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр

3.2.1.12. Аймаг, сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр

3.2.1.13. Улс, аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөө

**3.2.2. Хууль тогтоомж, тогтоол, шийдвэрт дараахь баримт бичиг хамаарна:**

3.2.2.1. Монгол Улсын хууль;

3.2.2.2. Улсын Их Хурлын тогтоол;

3.2.2.3. Улсын Их Хурлын Байнгын хорооны тогтоол;

3.2.2.4. Ерөнхийлөгчийн зарлиг;

3.2.2.5. Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн шийдвэр;

3.2.2.6. Засгийн газрын тогтоол;

3.2.2.7. Ерөнхий сайдын захирамж;

3.2.2.8. Засгийн газрын хуралдааны тэмдэглэл;

3.2.2.9. Засгийн газрын болон Ерөнхий сайдын албан даалгавар.

3.2.2.10. Аймаг, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол, шийдвэр;

3.2.2.11. Аймаг, сумын Засаг даргын захирамж, албан даалгавар;

**3.2.3. Захиргааны байгууллагын үйл ажиллагаанд:**

3.2.3.1. Энэ журмын 3.2.1, 3.2.2-т заасан баримт бичгийн хүрээнд хэрэгжүүлсэн үйл ажиллагаа;

3.2.3.2. Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт туссан Засгийн газрын тэргүүлэх ач холбогдолтой төсөл, арга хэмжээг үнэлэх шалгуур үзүүлэлтийн биелэлт; *(Засгийн газрын 2021 оны 374 дүгээр тогтоолоор нэмсэн бөгөөд үүнийг 2022 оны 6 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө)*

3.2.3.3. эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн биелэлт;

3.2.3.4. стратеги төлөвлөгөөний биелэлт;

3.2.3.5. байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт;

3.2.3.6. ил тод байдлыг хангах талаар хэрэгжүүлсэн үйл ажиллагаа;

3.2.3.7. шилэн дансны хөтлөлт;

3.2.3.8. байгууллагын дотоод үйл ажиллагаа;

3.2.3.9. Монгол Улсын Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутаг төлөөлөн хэрэгжүүлэх гэрээний хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт; *(Засгийн газрын 2021 оны 374 дүгээр тогтоолоор өөрчлөн найруулсан бөгөөд үүнийг 2022 оны 6 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө)*

3.2.3.10. аймгийн Засаг даргаас сумын Засаг даргатай байгуулсан гэрээний үүргийн биелэлт;

3.2.3.11.иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн тайлан;

3.2.3.12. төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн биелэлт;

3.2.3.13. гадаадын зээл, тусламжаар хэрэгжиж буй төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт.

3.2.3.14. аймгийн Засаг даргын захирамжаар батлагдсан арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт;

### **Дөрөв. Хяналт-шинжилгээ, үнэлгээний удирдлага, зохион байгуулалт**

4.1. Захиргааны байгууллага нь өөрийн хариуцсан асуудлын хүрээнд хуульд заасан чиг үүргийг хэрэгжүүлсэн байдалд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх үүрэг бүхий нэгж, эсхүл ажилтантай байна.

4.2. Аймгийн Засаг даргын тамгын газар нь бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг хэрэгжүүлэх, захиргааны байгууллагын үйл ажиллагааг үнэлж дүгнэх ажлыг аймгийн хэмжээнд нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангаж, биелэлтэд нь хяналт тавих, мэдээлэх үүргийг хариуцна.

4.3. Энэ журмын 4.2-т заасан үүргийг хэлтэс, агентлагийн дарга, сумын Засаг дарга, байгууллага, аж ахуйн нэгжид дарга (захирал, эрхлэгч) нар тус тус хариуцна.

4.4. Захиргаа, хүний нөөц, дотоод ажил хариуцсан нэгж бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, байгууллагын үйл ажиллагааны тайланг нэгтгэж, түүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ. Төрийн албан хаагч бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, байгууллагын үйл ажиллагааны тайланг тогтоосон хугацаанд үнэн зөв, бодитой гаргаж өгөх үүрэгтэй. Бодлогын баримт бичиг болон түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө боловсруулах шатанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан ажилтан, нэгжээс төлөөлөл оруулан хамтран ажиллана.

4.5. Тухайн байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээний нэгж байгууллагын чиг үүрэг, бүтэц, орон тооны хязгаарт нийцсэн үйл ажиллагаа явуулахад хүрэлцэхүйц бүрэлдэхүүнтэй байна.

4.6.Төрийн албаны тухай хуульд заасан төрийн албан хаагчид тавих шаардлагаас гадна дараахь шаардлагыг хангасан хүнийг бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэр, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх албан тушаалд томилно:

4.6.1. хяналт-шинжилгээ, үнэлгээний чиглэлээр болон тухайн салбарт гурваас доошгүй жил ажилласан туршлагатай байх;

4.6.2. хяналт-шинжилгээ, үнэлгээний чиглэлээр гадаад, дотоодын сургалтад хамрагдсан байх;

4.6.3. баримт бичигт дүн шинжилгээ хийх, үнэлэлт, дүгнэлт өгөх чадвартай байх.

### **Тав. Хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан ажилтны эрх, үүрэг**

5.1. Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх албан хаагч нь дараах эрхтэй байна:

5.1.1. байгууллагын дотоод нэгжүүдийн үйл ажиллагааны мэдээлэлтэй танилцах;

5.1.2. хяналт-шинжилгээ, үнэлгээнд хамаарах мэдээлэл, баримт, материалыг холбогдох нэгж, албан тушаалтнаас гаргуулан авах;

5.1.3. хяналт-шинжилгээ, үнэлгээний дүгнэлтээр зөвлөмж өгөх, өгсөн зөвлөмжийг хангалтгүй биелүүлсэн албан тушаалтанд хариуцлага тооцох саналыг эрх бүхий албан тушаалтанд гаргах;

5.1.4. хууль тогтоомжоор олгогдсон бусад эрх.

5.2. Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх албан хаагч нь дараах үүрэгтэй байна:

5.2.1. хууль тогтоомж, төрийн албаны ёс зүйн дүрмийг баримтлан ажиллах;

5.2.2. хяналт-шинжилгээ, үнэлгээний явцад олж авсан баримт, мэдээллийн нууцыг чанд хадгалж зөвхөн хяналт-шинжилгээ, үнэлгээний үйл ажиллагаанд ашиглах;

5.2.3. хяналт-шинжилгээ, үнэлгээний үнэлэлт, дүгнэлт, зөвлөмжийг хууль тогтоомж, баримт нотолгоонд үндэслэн гаргах;

5.2.4. тайлан дахь хүрсэн түвшний талаарх мэдээллийн үнэн, зөв эсэхийг нягтлан шалгах.

### **Зургаа. Хяналт-шинжилгээ, үнэлгээний төлөвлөлт, төрөл, арга зүй**

6.1. Хяналт-шинжилгээ, үнэлгээний төлөвлөлт, төрөл:

6.1.1. захиргааны байгууллага жил бүр хяналт-шинжилгээ, үнэлгээний төлөвлөгөөг батална. Энэхүү төлөвлөгөө нь тухайн байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээний нэгжийн төлөвлөгөө байж болно. Төлөвлөгөөнд зорилго, зорилт, хамрагдах байгууллага, нэгж, хэрэгжүүлэх хугацаа, зардал, хамтран оролцох байгууллага зэргийг тусгана;

6.1.2. захиргааны байгууллага нь үнэлгээний зорилгоос хамааруулан үр дүнд суурилсан явцын болон эцсийн үнэлгээ хийх бөгөөд хяналт-шинжилгээ, үнэлгээний төлөвлөгөөнд ямар төрлийн үнэлгээ хийх талаар нарийвчлан тусгана;

6.1.3. хөндлөнгийн үнэлгээг явцын болон эцсийн үнэлгээний аль ч шатанд хийж болох бөгөөд иргэд, төрийн бус байгууллагын төлөөллийг оролцуулж болно.

6.2. Хяналт-шинжилгээ, үнэлгээний арга зүй:

6.2.1. Бодлогын баримт бичигт хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхдээ урьдчилан тодорхойлсон шалгуур үзүүлэлтийн дагуу зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг дараахь аргачлалын дагуу хувиар илэрхийлэн үнэлнэ;

$$\text{Хэрэгжилт} = \frac{\text{Хүрсэн түвшин} - \text{Суурь түвшин}}{\text{Зорилтот түвшин} - \text{Суурь түвшин}} \cdot 100\%$$

6.2.2. Бодлогын баримт бичгийн зорилт, арга хэмжээний хүрсэн түвшинг тоо болон чанараар илэрхийлэх боломжгүй үед хэрэгжилтийн хувийг тодорхойлоход дараахь аргачлалаар тооцно.

6.2.2.1. зорилт, арга хэмжээний хүрэх түвшинд бүрэн хүрээгүй боловч зохион байгуулалтын арга хэмжээ бүрэн авагдсан, холбогдох байгууллагын шийдвэр гарсан, гол үр дүн нь гарч эхэлж байгаа бол 90.0 хувь;

6.2.2.2. тавьсан зорилт, арга хэмжээнд хүрэх зорилгоор өөрсдөөс хамаарах шийдвэрийг гаргасан, санхүүгийн асуудал шийдвэрлэгдсэн, дээд шатны байгууллагад өргөн барьсан буюу гүйцэтгэл нь тодорхой хэмжээгээр гарч эхэлж байгаа бол 70.0 хувь;

6.2.2.3. тухайн зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх бэлтгэл болон боловсруулалтын шатны ажил бүрэн хийгдсэн, ажил тодорхой хэмжээнд эхэлсэн бол 50.0 хувь;

6.2.2.4. тухайн зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх бэлтгэл ажил хийгдэж дуусаад боловсруулалтын шатанд байгаа бол 30 хувь;

6.2.2.5. тухайн зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардлагатай тооцоо, судалгаа хийх, асуудал тодорхойлох зэрэг бэлтгэл хангахтай холбогдсон үйл ажиллагааг авч эхэлж байгаа эсвэл хэрэгжүүлэх талаар ямар нэгэн ажил зохион байгуулаагүй бол биелэлтийг "0" хувь.

6.2.3. Бодлогын баримт бичгийн зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг энэ журмын 6.2.1, 6.2.2-т заасан аргачлалын дагуу тооцож, зорилт, арга хэмжээний дундаж үнэлгээгээр бодлогын зорилго, зорилтын хэрэгжилтийг дараахь ангилалд шилжүүлэн тооцно;

6.2.3.1. "үр дүнтэй"-зорилт, арга хэмжээ нь оновчтой тодорхойлогдсон, шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ бүрэн хүрсэн, удирдлага зохион байгуулалт сайн, үр дүн гарсан бол 100 хувь;

6.2.3.2. "тодорхой үр дүнд хүрсэн"-зорилт нь шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ бүрэн хүрээгүй, тодорхой үр дүн гарч эхэлж байгаа, хэрэгжилт, үр дүнг нэмэгдүүлэх шаардлагатай бол 70-100 хүртэл хувь; *(Засгийн газрын 2021 оны 374 дүгээр тогтоолоор өөрчлөлт орсон бөгөөд үүнийг 2022 оны 6 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө)*

6.2.3.3. "эрчимжүүлэх шаардлагатай"-зорилт нь шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ хүрээгүй, удирдлага, зохион байгуулалт, хариуцлагыг сайжруулж, үйл ажиллагааг эрчимжүүлэх, зорилтод чиглэсэн арга хэмжээг сайжруулах шаардлагатай бол 30-70 хүртэл хувь; *(Засгийн газрын 2021 оны 374 дүгээр тогтоолоор өөрчлөлт орсон бөгөөд үүнийг 2022 оны 6 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө)*

6.2.3.4. "үр дүнгүй"-зорилт, арга хэмжээг илүү сайн тодорхойлох шаардлагатай, шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ хүрээгүй, төсөв хөрөнгийг үр дүнтэй зарцуулж чадаагүй, удирдлага зохион байгуулалт хангалтгүй бол 0-30 хүртэл хувь.

6.3. Хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн зүйл, заалтын хэрэгжилтийн үнэлгээг дараахь аргачлалаар тооцно:

6.3.1. "бүрэн хэрэгжсэн"-холбогдох шийдвэр гарч тавьсан зорилтдоо бүрэн хүрсэн, үр дүн гарсан бол 100 хувь (90-100 хүртэл хувь);

6.3.2. "хэрэгжих шатанд"-тавьсан зорилтдоо бүрэн хүрээгүй боловч төсөв, санхүүгийн асуудлыг шийдсэн, зохион байгуулалтын арга хэмжээ авсан, дээд шатны байгууллагад өргөн барьсан, холбогдох байгууллагын шийдвэр гарсан, гол үр дүн нь гарч байгаа бол 70 хувь (50-90 хүртэл хувь); *(Засгийн*



газрын 2021 оны 374 дүгээр тогтоолоор өөрчлөлт орсон бөгөөд үүнийг 2022 оны 6 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө)

6.3.3. "хэрэгжилт хангалтгүй"-тухайн зорилтыг хэрэгжүүлэх бэлтгэл ажил болон боловсруулалт хийгдэж дууссан боловч зохион байгуулалт, төсөв, санхүүгийн асуудал шийдэгдээгүй бол 30 хувь (10-50 хүртэл хувь); (Засгийн газрын 2021 оны 374 дүгээр тогтоолоор өөрчлөлт орсон бөгөөд үүнийг 2022 оны 6 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө)

6.3.4. "хэрэгжээгүй"-тухайн зорилтыг хэрэгжүүлэхэд шаардлагатай тооцоо судалгаа, бэлтгэл ажил хийгдэж боловсруулалтын шатанд байгаа болон тухайн зорилтыг хэрэгжүүлэх талаар ямар нэгэн ажил зохион байгуулаагүй бол 0 хувь (0-10 хүртэл хувь);

6.3.5. "хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй".

6.4. Бодлогын баримт бичгийн зорилго, зорилт, арга хэмжээ, хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийн ерөнхий дүнг гаргахдаа зорилт, арга хэмжээ, зүйл, заалт бүрийн хэрэгжилтийн арифметик дунджаар тооцно.

6.5. Хэлтэс, агентлаг, сум, багийн тухайн жилийн үйл ажиллагааны үнэлгээний дүнг гаргахдаа үзүүлэлт бүрийн үнэлгээг 100 хүртэл хувиар илэрхийлэн нийлбэр үнэлгээний арифметик дунджийг харгалзах жинд шилжүүлнэ. Ерөнхий үнэлгээг тодорхойлохдоо жинд шилжүүлсэн дүнгүүдийн нийлбэрийг 0.05-аар үржүүлж, 0-5 хүртэл оноонд шилжүүлэн дүгнэнэ;

E-ерөнхий үнэлгээ;

-бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн хувь;

β-байгууллагын чиг үүргийн биелэлтийн хувь;

γ-байгууллагын нээлттэй байдлын үнэлгээ;

-бодлогын баримт бичгийн тоо;

m-байгууллагын чиг үүргийн үзүүлэлтүүдийн тоо;

k-байгууллагын нээлттэй байдлын үзүүлэлтүүдийн тоо;

i-үзүүлэлтийн дугаар.

$$E = 0.05 * \left[ \left( \frac{1}{n} \sum_{i=1}^n (\alpha_i) \right) * 0.6 + \left( \frac{1}{m} \sum_{i=1}^m (\beta_i) \right) * 0.2 + \left( \frac{1}{k} \sum_{i=1}^k (\gamma_i) \right) * 0.2 \right]$$

6.6. Бодлогын баримт бичгийн зорилт, арга хэмжээ, хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилтэд хоёр удаагийн тайлангийн хугацаанд дараалан ахиц гараагүй бол удааширсан, гурван удаагийн тайлангийн хугацаанд мөн ахиц гараагүй бол тасарсанд тооцно.

6.7. Монгол Улсын Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх гэрээний хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт, аймгийн Засаг даргаас хэлтэс, агентлаг, сумын Засаг даргатай байгуулсан гэрээний үүргийн хэрэгжилт, стратеги төлөвлөгөө, байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг үнэлэхдээ бодлогын баримт бичиг үнэлэх аргачлал, байгууллагын ил тод байдлыг хангах талаар хэрэгжүүлсэн үйл ажиллагааг үнэлэхдээ хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийн үнэлгээ тооцдог аргачлалыг тус тус

баримтална. *(Засгийн газрын 2021 оны 374 дүгээр тогтоолоор өөрчлөлт орсон бөгөөд үүнийг 2022 оны 6 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө)*

6.8. Хэрэгжилтийн тайланг дээд шатны байгууллагад тайлагнахдаа тухайн зорилт, арга хэмжээ, заалтын гүйцэтгэл, үр дүнг хоёр мянган тэмдэгтэд багтаана.

6.9. Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, үр дүнд хүрсэн эсэх, хүрээгүй бол түүний шалтгаан нөхцөлийг тодорхой тусгана.

**Долоо. Бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх**

7.1. Бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх үйл ажиллагааны зорилго нь баримт бичгийн төлөвлөлт, биелэлтэд чанарын үнэлгээ хийх, хэрэгжүүлсэн үйл ажиллагаа, шийдвэр нь үр дүнтэй байсан эсэхэд чанарын үнэлгээ хийх, үр нөлөөг үнэлэхэд оршино.

7.2. Бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтэд дараах үе шатаар цогц хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ:

7.2.1. мэдээллийг цуглуулах, ангилах, нэгтгэх;

7.2.2. зорилтын биелэлтийн дүнг үнэлэх;

7.2.3. биелэлтийн үр нөлөөг үнэлэх;

7.2.4. гадаад, дотоод хүчин зүйлийн нөлөөллийг үнэлэх;

7.2.5. төлөвлөлт, хэрэгжилтийн харилцан хамаарлыг үнэлэх;

7.2.6. биелэлтийн түвшинг үнэлэх;

7.2.7. бодлогын баримт бичгийн төлөвлөлт, хэрэгжилтийг сайжруулах тодорхой санал боловсруулах.

7.3. Захиргааны байгууллага нь бодлогын баримт бичигт тодорхойлсон төлөвлөгөөний дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ. Бодлогын баримт бичигт хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхдээ урьдчилан тодорхойлсон шалгуур үзүүлэлтийн дагуу энэ журмын 6.2.1, 6.2.2-т заасан аргачлалаар үнэлнэ.

7.4. Шаардлагатай тохиолдолд харьяалах дээд шатны байгууллага нь бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг газар дээр нь шалгаж, тайланг хэлэлцэн түүний мөрөөр холбогдох арга хэмжээг авна.

7.5. Энэ журмын 3.2.1-д заасан бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний явцын болон эцсийн тайланг мөн журмын 2-3 дугаар хавсралтын дагуу гаргаж, журмын 1 дүгээр хавсралтад заасан хугацаанд холбогдох байгууллагад хүргүүлнэ.

7.6. Захиргааны байгууллага нь урт болон дунд хугацаанд хэрэгжих бодлогын баримт бичгийг хүчингүй болсонд тооцсон, эсхүл хугацаа дуусмагц эцсийн үнэлгээ болон бодлогын баримт бичгийн үр нөлөөний үнэлгээг хийж, дүнг энэ журмын 11 дүгээр хавсралтын дагуу гарган аймгийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлнэ. *(Засгийн газрын 2021 оны 374 дүгээр тогтоолоор өөрчлөн найруулсан бөгөөд үүнийг 2022 оны 6 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө)*

7.7. Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, зорилт арга хэмжээний төлөвлөлт, төсөвлөлт, тайлагналтын харилцан хамраалыг үнэлэхдээ Хөгжлийн бодлого, төлөвлөлт түүний удирдлагын тухай хуульд нийцүүлэн төлөвлөгөөгүй бол сул төлөвлөлт гэж үзэн хэрэгжилтийн үнэлгээг 20 хувиар бууруулна.

7.8 Тайланд тавигдах шаардлагад нийцүүлэн тайлагнаагүй бол тайлангийн чанар муу гэж үзэн хэрэгжилтийн үнэлгээг 10 хувиар бууруулна.

7.9. Дээрх 2 алдаа зорилт, арга хэмжээний төлөвлөлт, тайлагналт дээр зэрэг гарсан бол хэрэгжилтийн үнэлгээг 20 хувиар бууруулна.

7.10. Байгууллагын болон төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө бодлогын баримт бичгийн уялдаа хангагдаагүй, холбогдох журам зааврыг мөрдөөгүй бол үнэлгээг 10 хувиар бууруулна.

7.11. Баримт бичгийн хэрэгжилтийг тайлагнахдаа хугацаа хоцроосон бол үнэлгээг 5 хувиар бууруулна.

7.12. Баримт бичгийн хэрэгжилтийг сумын Засаг даргын зөвлөл, байгууллагын даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлээгүй, тамга, тэмдэг дарж баталгаажуулаагүй бол үнэлгээг 2 хувиар бууруулна.

7.13. Тухайн баримт бичгийн хэрэгжилтийн үнэлгээг шууд уялдаатай хөгжлийн үзүүлэлтүүдийн өөрчлөлттэй харьцуулан үнэлгээг 20 хүртэл хувиар нэмэгдүүлж, бууруулж болно.

#### **Найм. Хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх**

8.1. Захиргааны байгууллага нь хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг хяналтад авч, хэрэгжилтийг салбар, чиглэлээр ангилан энэхүү журмын 5 дугаар хавсралтын дагуу гаргаж тайланг журмын 1 дүгээр хавсралтад заасан хугацаанд хүргүүлнэ.

8.2. Захиргааны байгууллага нь хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн явцад хагас, бүтэн жилээр хяналт-шинжилгээ хийж дүнг агентлаг, сумын Засаг даргын Зөвлөлийн хуралд танилцуулах бөгөөд хурлаас гарсан шийдвэрийг тайлангийн хамт аймгийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлнэ.

8.3. Захиргааны байгууллага бодит шалтгааны улмаас хэрэгжих боломжгүй, цаг хугацааны хувьд ач холбогдолгүй болсон сүүлийн 3 жил тасарсан болон тухайн асуудлаар дахин шийдвэр гарсан хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн заалтыг хүчингүй болгох, хяналтаас хасах тухай саналыг жилийн эцсийн тайлангийн хамт аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэст хүргүүлнэ.

8.4. Шаардлагатай гэж үзвэл аймгийн Засаг даргын Тамгын газар нь хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг газар дээр нь шалгаж, тайлан, мэдээллийг хэлэлцэн тэдгээрийн мөрөөр холбогдох арга хэмжээг авна.

#### **Ес. Захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх**

9.1. Хэлтэс, агентлаг, сумдын Засаг даргын Тамгын газар нь тухайн жилийн үйл ажиллагааны үр дүнд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланг энэхүү журмын 6, 7, 8 дугаар хавсралтын дагуу гаргаж, тайланг журмын 1 дүгээр хавсралтад заасан хугацаанд ирүүлнэ.

9.2. Сум, байгууллага нь журмын 9, 10 дугаар хавсралтад заасан эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтүүдийн хэрэгжилтийг хангаж, биелэлтийг үнэн зөв тайлагнана.

9.3. Сум, байгууллагын тухайн жилийн байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хагас, бүтэн жилээр гаргаж, хяналт-шинжилгээ, үнэлгээ

хийж, дүнг байгууллагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн, тайланг журмын 1 дүгээр хавсралтад заасан хугацаанд аймгийн Засаг даргын Тамгын газарт ирүүлнэ.

9.4.Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хэрэгжилтийг журмын 4 дүгээр хавсралтын маягтын дагуу 1 дүгээр хавсралтад заасан хугацаанд аймгийн Засаг даргын Тамгын газарт ирүүлнэ.

**9.5.Мэдээллийн ил тод, нээлттэй байдлын үнэлгээний тайланг журмын 12 дугаар хавсралтын маягтын дагуу 1 дүгээр хавсралтад заасан хугацаанд аймгийн Засаг даргын Тамгын газарт ирүүлнэ.**

9.6.Шилэн дансны хөтлөлтийг төсвийн захирагч, санхүүгийн албаны дарга нар хангуулж, нягтлан бодогч хариуцан тайлагнана. Тайланг Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба нэгтгэн дүгнэж, дүн мэдээг 1-р хавсралтад заасан хугацаанд гаргана.

**9.7. Монгол Улсын Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх гэрээний үүргийн хэрэгжилтийг журмын 13б хавсралтаар гаргаж, 1 дүгээр хавсралтад заасан хугацаанд аймгийн Засаг даргын Тамгын газарт ирүүлнэ.**

**9.8. Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт туссан Засгийн газрын тэргүүлэх ач холбогдолтой төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийн үнэлгээг журмын 14 дүгээр хавсралтаар гаргаж, 1 дүгээр хавсралтад заасан хугацаанд аймгийн Засаг даргын Тамгын газарт ирүүлнэ.**

9.9. Аймгийн Засаг даргын Тамгын газар нь шаардлагатай гэж үзсэн тохиолдолд ажлын хэсэг байгуулан орон нутагт газар дээр нь ажиллан хэлтэс, агентлаг, сумын Засаг дарга, түүний Тамгын газрын жилийн үйл ажиллагааны нэгдсэн үнэлгээг гаргана.

9.10. Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ үнэлгээний хэлтэс (ажлын хэсэг) нь сум, байгууллагуудын жилийн үйл ажиллагааны үнэлгээний дүнг аймгийн Засаг даргын Зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлнэ.

#### **Арав. Хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим сан**

10.1. Бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, захиргааны байгууллагын үйл ажиллагааг үнэлэх, тайлан илгээх, хүлээн авах, мэдээллийн урсгалыг удирдах, хянах, хадгалах, ашиглах, түгээхэд Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим сан (цаашид "цахим сан"-г) ашиглана.

10.2. Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим санг ашиглах зааврыг Засгийн газрын Хэрэг эрхлэх газар баталж, захиргааны байгууллагыг удирдлага, зохицуулалтаар хангаж ажиллана. Орон нутгийн түвшинд аймгийн Засаг даргын Тамгын газар удирдлага, зохицуулалтаар хангаж, захиргааны байгууллагууд холбогдох мэдээллүүдийг хариуцан цахим санд мэдээллэх үүрэгтэй ажиллана.

10.3. Аймгийн Засаг дарга, Засаг даргын Тамгын газар, хэлтсийн дарга өөрийн эрхээр нэвтэрч хянан баталгаажуулж, холбогдох албан тушаалтан нь бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, байгууллагын үйл ажиллагааны тайланг цахим санд оруулна.

10.4. Хэрэгжилтийн тайланг цахим санд оруулахдаа тухайн зорилт, арга хэмжээ, заалтын хүрсэн үр дүнг хоёр мянган тэмдэгтэд багтаах бөгөөд шаардлагатай бол нотлох баримтыг файлаар хавсаргаж болно.

10.5. Цахим санд мэдээлэл оруулж байгаа байгууллага, албан хаагч мэдээллийн үнэн зөв, бодит байдлыг хариуцна.

10.6. Цахим сангийн ил тод байдлыг хангах зорилгоор олон нийтэд зориулагдсан нээлттэй хэсэгтэй байна.

### **Арван нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүнг хэрэгжүүлэх**

11.1. Жилийн үйл ажиллагааны үр дүнгээр шалгарсан сум, баг, байгууллагыг дор дурдсанаар шагнаж урамшуулна. Мөн тэргүүнээр шалгарсан сумын Засаг дарга, Засаг даргын Тамгын газрын дарга, баг, байгууллагын дарга тус бүрт 1 сарын үндсэн цалинтай тэнцэх мөнгөн урамшуулал олгоно.

#### **Сум:**

1 дүгээр байр: Өргөмжлөл 1000.0 (нэг сая төгрөг)

2 дугаар байр: Өргөмжлөл 800.0 (найман зуун мянган төгрөг)

3 дугаар байр: Өргөмжлөл: 500.0 (таван зуун мянган төгрөг)

#### **Баг:**

1 дүгээр байр: Өргөмжлөл 500.0 (таван зуун мянган төгрөг)

2 дугаар байр: Өргөмжлөл 300.0 (гурван зуун мянган төгрөг)

3 дугаар байр: Өргөмжлөл 200.0 (хоёр зуун мянган төгрөг)

#### **Байгууллага:**

1 дүгээр байр: Өргөмжлөл 1000.0 (нэг сая төгрөг)

2 дугаар байр: Өргөмжлөл: 800.0 (найман зуун мянган төгрөг)

3 дугаар байр: Өргөмжлөл 500.0 (гурван зуун мянган төгрөг)

11.2 Захиргааны байгууллага хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланд дурдсан зөвлөмж, дүгнэлтийн дагуу холбогдох арга хэмжээг авч дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

11.2.1. Сум, байгууллагуудын үйл ажиллагааны үнэлгээний дүнг хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд ил тод мэдээлэх, тэргүүний арга, туршлагыг түгээн дэлгэрүүлэх;

11.2.2. Захиргааны байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх чиглэлээр сургалт зохион байгуулах;

11.2.3. Харьяалах захиргааны байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх талаар үүрэг, чиглэл өгөх, шаардлагатай тохиолдолд зохих удирдамжийн дагуу газар дээр нь хяналт шалгалт хийж, дүгнэлт гаргах;

11.3. Захиргааны байгууллага хяналт-шинжилгээ, үнэлгээг холбогдох газар дээр нь хийхэд, эрдэмтэн, судлаачдыг үнэлгээ хийхэд татан оролцуулах, хэрэглэгчийн болон хөндлөнгийн үнэлгээ хийлгэх, сургалт зохион байгуулах, сургалтын материал, ном, товхимол, гарын авлага хэвлүүлэх зэрэг зардлыг байгууллагын төсөвт жил бүр тусган батлуулж, хэрэгжүүлнэ.

11.4. Хяналт-шинжилгээ, үнэлгээний явцын болон эцсийн дүгнэлт, зөвлөмжид үндэслэн тухайн бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, нэмэлт, өөрчлөлт оруулах болон шаардлагатай бусад арга хэмжээ авах үйл ажиллагааг холбогдох байгууллага, албан тушаалтан хариуцан зохион байгуулна.

### **Арван хоёр. Хариуцлага**

12.1. Үйл ажиллагааны үр дүнгээр сүүлийн байранд орсон 3 сумын Засаг дарга, 3 байгууллагын даргын мэдээллийг Аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар авч хэлэлцэн холбогдох арга хэмжээг авна.

12.2. Бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэр, байгууллагын үйл ажиллагааны үнэлгээний дүнгээр хоёр удаа хангалтгүй үнэлгээ авсан, эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлт нь буурсан сум, байгууллагын даргыг Төрийн

албаны тухай хуулийн 45.1-д заасны дагуу албан тушаал бууруулах саналыг эрх бүхий албан тушаалтанд гаргах.

12.3. Дараах зөрчил гаргасан албан тушаалтанд Төрийн албаны тухай, Төсвийн тухай болон холбогдох бусад хуульд зааснаар хариуцлага хүлээлгэнэ.

12.3.1 Энэхүү журмын 3.1, 4.4-т заасныг зөрчиж худал, зөрүүтэй мэдээллээр тайлагнасан;

12.3.2. Өгсөн зөвлөмжийг биелүүлээгүй;

12.3.3. Тайлан мэдээг хугацаанд нь гаргаж ирүүлээгүй удаа дараа шаардуулсан

**БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ, ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ,  
БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ТАЙЛАГНАХ ХУГАЦАА**

Журмын 1 дүгээр хавсралт

д/д	Тайлангийн төрөл	Тайлан гаргах Байгууллага	Тайланг хүлээн авах байгууллага, хугацаа	Хяналт- шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэст ирүүлэх хугацаа	Засаг даргын зөвлөлд оруулах хугацаа	Давтамж	Холбогдох дээд шатны байгууллагад хүргүүлэх хугацаа
-----	------------------	------------------------------	--	--	---	---------	---

**Нэг. Бодлогын баримт бичиг**

1	Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого-"Алсын хараа 2050"	Аймгийн ЗДТГ-ын хэлтсүүд, захиргааны байгууллагууд	Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс 08.05	08.10	-	Явцыг-жил тутам ХШҮ-5 жил тутам	Үндэсний хөгжлийн бодлого төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага 09.01
2	Хөгжлийн зорилгот хөтөлбөр	сумдын ЗДТГ-азар, холбогдох захиргааны байгууллагууд	Аймгийн Засаг даргын Тамгын газрын холбогдох хэлтсүүдэд 07.05	07.10	-	Явцыг-жил тутам ХШҮ-5 жил тутам	Үндэсний хөгжлийн бодлого төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага 08.01
3	Хуульд нийцүүлэн хучингүй болсонд тооцсон болон хугацаа дууссан	Аймгийн ЗДТГ-ын хэлтсүүд, захиргааны байгууллагууд	Хучингүй болсон хугацаа дууссан өдрөөс хойш 6 сарын дотор	ХШҮ-ний хэлтэст	-	Явцыг-хагас жилд 1 удаа	Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт Хагас жил тутам

	Бодлогын Баримт Бичгийн тайлан							Үндэсний хөгжлийн Бодлого Төлөвлөлтийн асуудал
4	Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн Чиглэл	Аймгийн ЗДТГ-ын хэлтсүүд, сумдын ЗДТГ-аар, захиргааны байгууллагууд	Аймгийн Засаг даргын Тамгын газрын холбогдох хэлтсүүдэд 12.05	12.10	-	Явцыг-жил тутам ХШҮ-5 жил тутам	эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага 01.01	
5	Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр	Аймгийн ЗДТГ-ын хэлтсүүд, захиргааны байгууллагууд	Аймгийн Засаг даргын Тамгын газрын холбогдох хэлтсүүдэд 06.05 12.05	06.10 12.10	12.20	Явцыг-жил тутам	ЗГХЭГ 01.01 07.01	
6	Аймаг, хотыг хөгжүүлэх таван жилийн үндсэн Чиглэл	сумдын ЗДТГ-аар, захиргааны байгууллагууд	Аймгийн Засаг даргын Тамгын газрын холбогдох хэлтсүүдэд 06.01 11.01	06.10 11.05	12.01 /ИТХ-аар хэлэлцүүлнэ./	Явцыг-жил тутам ХШҮ-2 жил тутам	Үндэсний хөгжлийн Бодлого Төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага 03.01	
7	Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр	сумдын ЗДТГ-аар, захиргааны байгууллагууд	Аймгийн Засаг даргын Тамгын газрын холбогдох хэлтсүүдэд 05.30 11.01	06.10 11.05	12.01 /ИТХ-аар хэлэлцүүлнэ./	Явцыг-жил тутам	ЗГХЭГ 02.01	
8	Аймаг, хотыг хөгжүүлэх жилийн төлөвлөгөө	сумдын ЗДТГ-аар, захиргааны байгууллагууд	Аймгийн Засаг даргын Тамгын газрын холбогдох хэлтсүүдэд	06.10 11.05	12.01 /ИТХ-аар хэлэлцүүлнэ./	Явцыг-жил тутам	ЗГХЭГ 02.01	



			05.30 11.01					
9	Сумын Засаг даргын Үйл ажиллагааны хөтөлбөр /тогтоолын хамт/	Сумдын Засаг даргын Тамгын газар	Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс 06.20 12.28	-	-	12.20 /сумын ИТХ- аар хэлэлцүүлнэ./	Явцыг-жил тутам	-
10	Сумын хөгжлийн жилийн төлөвлөгөө /тогтоолын хамт/	Сумдын Засаг даргын Тамгын газар	Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс 06.20 12.28	-	-	12.20 /сумын ИТХ- аар хэлэлцүүлнэ./	Явцыг-жил тутам	-

**Хоёр. Хууль тогтоомж, тогтоол шийдвэр**

11	Монгол Улсын хууль, УИХ-ын шийдвэр, Ерөнхийлөгчийн зарлиг, ҮАБЗ-ийн зөвлөмж, Засгийн газрын шийдвэр	сумдын ЗДТГазар, захиргааны байгууллагууд	Аймгийн Засаг даргын Тамгын газрын холбогдох хэлтсүүдэд 3, 6, 9, 12 сарын 05-ны дотор	3, 6, 9, 12 сарын 10-ны дотор	06.20 12.20	Явцыг-жил тутам	ЗГХЭГ 01.15 07.01
12	Засгийн газрын зарим чиг үүргийг төлөөлөн хэрэгжүүлэх гэрээний хэрэгжилт	Захиргааны байгууллагууд	Аймгийн ЗДТГ-ын холбогдох хэлтэст 06.10 12.10	06.15 12.15	-	Явцыг-хагас, бүтэн жил	Холбогдох яамдад 06.20 12.20
13	Аймгийн Засаг даргаас сумын Засаг даргатай байгуулсан гэрээ	сумдын ЗДТГазар	Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс 06.15 12.15	-	-	Явцыг-хагас, бүтэн жил	-
14	Аймгийн Засаг даргаас хэлтэс агентлаг, байгууллагын дарга нартай байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт	Захиргааны байгууллагууд	Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс 06.15 12.15	-	-	Явцыг-хагас, бүтэн жил	-

15	Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын тогтоол, шийдвэрийн биелэлт	Аймгийн ЗДТГ-ын хэлтсүүд, сумдын ЗДТГазар, байгууллагууд	Төрийн захиргааны удирдлагын хэлтэс 06.10 11.10	-	Явцыг-хагас, бүтэн жил	АИТХ-ын Тэргүүлэгчдийн хурал 12.01
16	Аймгийн Засаг даргын албан даалгавар, захирамжийн биелэлт	Аймгийн ЗДТГ-ын хэлтсүүд, сумдын ЗДТГазар, байгууллагууд	Хууль, эрх зүйн хэлтэс 12.01	12.10	-	-
<b>Гурав. Төсөл</b>						
17	Гадаадын зээл, тусламжаар хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт	Аймгийн ЗДТГ-ын хэлтсүүд, сумдын ЗДТГазар, захиргааны байгууллагууд	Төрийн захиргааны удирдлагын хэлтэс 02.01	02.10	-	Санхүү, төсийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага 03.01
<b>Дөрөв. Байгууллагын үйл ажиллагаа</b>						
18	Агентлаг, сүм, багийн тухайн жилийн үйл ажиллагааны тайлан	Агентлагын дарга, Сумын ЗДТГ-ын дарга	Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс 12.15	-	01.10	Аймгийн Засаг даргын Зөвлөлийн хурал
19	Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хэрэгжилт	сумдын ЗДТГазар, захиргааны байгууллагууд	Төрийн захиргааны удирдлагын хэлтэс 01.10	01.25	-	Явцыг-жил тутам ЗГХЭГ 03.01
20	Байгууллагын ил тод байдлын үнэлгээ	Аймгийн ЗДТГ-ын Төрийн захиргааны удирдлагын хэлтэс, Сумдын ЗДТГазар, Захиргааны байгууллагууд	Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс 01.10	01.20	-	Явцыг-жил тутам ЗГХЭГ 03.01

21	Шилэн дансны хөтлөлтийн үнэлгээ	Сумдын ЗДТГ-аар, Захиргааны байгууллагууд	Санхүүгийн хяналт, Дотоод аудитын алба 01.10	01.20	-	Явцыг-жил тутам	ЗГХЭГ 03.01
22	Хяналт-шинжилгээ, үнэлгээгээр өгөгдсөн үүрэг даалгавар, зөвлөмжийн хэрэгжилт	Сумдын ЗДТГ-аар, Захиргааны байгууллагууд	Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс 06.15 12.15	-	-	Явцыг-хагас, бүтэн жил	АЗДТГ 06.20 12.20
23	Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт туссан Засгийн газрын тэргүүлэх ач холбогдолтой төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийн үнэлгээ	Сумдын ЗДТГ-аар, Захиргааны байгууллагууд	Төрийн захиргааны удирдлагын хэлтэс Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс 06.15 12.15	-	-	Явцыг-хагас, бүтэн жил	АЗДТГ 06.20 12.20



**БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ТАЙЛАГНАХ ХҮСНЭГТ**

Д/д	Үндэслэж байгаа бодлогын баримт бичиг	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин		Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу гүйцэтгэлийн хувь /хүрээгүй бол шалтгаан, нөхцөл тайлбар/
				Он	Түвшин		
Бодлогын баримт бичгийн зорилго 1							
1.	Зорилт 1						
1.1	Арга хэмжээ						
1.2	Арга хэмжээ						
1.3	Арга хэмжээ						
Бодлогын баримт бичгийн зорилго 2							
2.	Зорилт 2						
2.1	Арга хэмжээ						
2.2	Арга хэмжээ						
2.3	Арга хэмжээ						

**Тайлбар :** Аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл [redacted] энэ хүснэгтийн дагуу гаргана.

УРТ, ДУНД ХУГАЦААНЫ ХӨГЖЛИЙН БОДЛОГО,  
ТӨЛӨВЛӨЛТИЙН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ТАЙЛАГНАХ ЗАГВАР

Бүлгийн нэр:

Зорилго:

Зорилт:

Үйл ажиллагаа:

Санхүүжилтийн эх үүсвэр, зарцуулсан хөрөнгийн хэмжээ: (Хөгжлийн зорилтот хөтөлбөрт хамаарна)

Хэрэгжилт/үр дүн:

(Засгийн газрын 2021 оны 374 дүгээр тогтоолоор өөрчлөн баталсан бөгөөд үнийг 2022 оны 6 дугаар сарын 1-ний өдрөөс  
эхлэн дагаж мөрдөнө)

---00---



... ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ ТАЙЛАГНАХ ХҮСНЭГТ (... ОН)



Дугаар	ХБТББ*-т тусгагдсан зорилт/үйл ажиллагаа	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ**	Хэрэгжих хугацаа	Үндсэн хэрэгжүүлэх байгууллага	Эх үүсвэр	Нийт хөрөнгийн хэмжээ (сая төгрөг)	Суурь түвшин	Зорилтот түвшин, үр дүн (хөрөнгийн хэмжээ)			Хэрэгжилт ийн явц	Хэрэгжилт ийн хувь
								Зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Төсөв (сая. төг)	Төсвийн гүйцэтгэл (сая. төг)		
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13
Бүлгийн нэр:												

\* Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг

\*\* Хөгжлийн жилийн төлөвлөгөөний хувьд төсөл, арга хэмжээ гэж ойлгоно.

(Засгийн газрын 2021 оны 374 дүгээр тогтоолоор өөрчлөн баталсан бөгөөд үүнийг 2022 оны 6 дугаар сарын 1-ний өдөрөөс эхлэн дагаж мөрдөнө)

... ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ, ЗОРИЛТОТ  
ТҮВШИНГ ТАЙЛАГНАХ ХҮСНЭГТ (... ОН)



Дугаар	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Үндсэн байгууллага	хэрэгжүүлэх	Суурь түвшин	Зорилгот түвшин	Хүрсэн түвшин	Хэрэгжилтийн хувь
1	2	3	4	5	6	7	8	
Бүлгийн нэр								

(Засгийн газрын 2021 оны 374 дүгээр тогтоолоор өөрчлөн баталсан бөгөөдүүнийг 2022 оны 6 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө)

**ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН СУРГАЛТ, АЖИЛЛАХ НӨХЦӨЛ, НИЙГМИЙН БАТАЛГААГ ХАНГАХ ХӨТӨЛБӨРИЙН  
БИЕЛЭЛТИЙГ ТАЙЛАГНАХ ХҮСНЭГТ (..... он)**



№	Үйл ажиллагаа	Д/д	Шалгуур үзүүлэлт	Зорилто		Тайлбар
				т түвшин	Хүрсэн түвшин	
<b>Хүний нөөцийг хөгжүүлэх, идэвхжүүлэх</b>						
1.	Засгийн газар, төрийн байгууллага, бусад байгууллагаас албан хаагчдын мэдлэг, мэргэжлийг дээшлүүлэх чиглэлээр зохион байгуулсан дотоод сургалт	1.1.	Нийт сургалт, семинар, зөвлөгөөний тоо	-	-	1. Нэг удаагийн сургалтын хугацаа 4 цагаас дээш бол тайлагнана 2. Зорилгот түвшин хэсэгт байгууллагын сургалтын төлөвлөгөөнд туссан дүнг бичнэ 3. Гадаад улс орон, хилийн чандад хамрагдсан сургалтыг тайлагнана 4. Дэлгэрэнгүй судалгаа мэдээллийг тайланд хавсаргасан байна.
			- Ажлын байран дахь сургалт	-	-	
			- Мэргэшүүлэх сургалт	-	-	
